

ЦОГТ ХУВЬСГАЛЧ ПЭН БАЙ
(Цаазлагдсаны нь 50 жилийн ойд)

Пэн Бай 1896 оны 10-р сарын 22-нд Гуаньдун мужид газрын эзний гэрт төржээ. 1921-1922 онд ЗХУ-ын Москва хотын Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист их сургуульд суралцсан нь түүнд марксист үзэл санаа бүрэлдэн тогтоход нь их үүрэг гүйцэтгэжээ. 1922 онд нутагтаа буцаж очоод хөдөө тосгоноор явж тариачдын дунд хувьсгалт үзэл санаа бүрэлдүүлэх суртал ухуулгын ажлыг идэвхитэй хийж, улмаар Хятадын тариачны анхны холбоог байгуулжээ.¹ Тэр холбоо нь 1923 онд 30 хүнтэй болон өргөжин «Нэгдсэн холбоо» нэртэйгээр Хайфун хошуунд төвлөрчээ. Пэн Байгаар удирдуулсан уг холбоо тариачдад мөнгөн тусламж үзүүлэх, эмнэлгээр үйлчлэх, ялангуяа тариачдын дунд зохиох соёл гэгээрлийн ажлыг их анхаарч түүнийг улс төрийн тэмцэлтэй хослуулан явуулж байжээ. Тэр нь тухайн үед ХКН-аас тариачдын дунд зохиох ажлын нэгэн чухал хэсэг болж байв. Хятадын өргөн олон тариачдын дунд хувьсгалт ажил зохиоход зохих хэмжээний боловсон хүчин бэлтгэх шаардлагатай байжээ. Иймээс тариачдын дотроос боловсон хүчин бэлтгэх түр курс нээн ажиллуулж, түүнийг Пэн Бай биечлэн удирдаж байжээ. 1924 онд тэр курс анхны төгсөлтөө хийсэн бөгөөд хоёр жилийн дараа төгсөгчдийн тоо 554 болжээ.²

Пэн Бай тариачны хөдөлгөөн, хувьсгалт тэмцэлд тэдний гүйцэтгэх үүрэг ролийн талаар тогтмол лекц яриа хийж, олон түмний хурал зөвлөлгөөнд илтгэл тавьдаг байжээ. 1924 оны хавар тэрээр «Хайфун хошуун дахь тариачны хөдөлгөөний тухай илтгэл» хэмээх товхимолдоо тариачны асуудлыг марксист онолын үүднээс тайлбарлаж тариачин нь ажилчин ангийн холбоотон хэрхэн болох тухай асуудлыг нарийвчлан тайлбарлаж, хувьсгалт хөдөлгөөнд ажилчин ангийн удирдах үүргийг тодорхойлсон ажээ. Энэ бол тэр үеийн хятадын коммунистуудаас Хятадын хувьсгалд тариачдын гүйцэтгэх ролийн талаар хийсэн анхны дүн шинжилгээ байв. Хятадын хувьсгалын түүхэнд Мао Зэдүнээс бүр өмнө тариачны асуудлыг анх хөндөн судалж зохих дүгнэлтийг дэвшүүлсэн хүн Пэн Бай байлаа. Гэтэл маоист түүхчид хятадын хувьсгалт ажилчин тариачны холбоог бэхжүүлэх явцад түүний оруулсан хувь нэмрийг дурдалгүй өнгөрч харин Мао Зэдүнийг хятадын хувьсгалд тариачны ролийг анх нээсэн хэмээн өргөмжилж түүний 1927 оны 3-р сард бичсэн «Хунань дахь тариачны хөдөлгөөний тухай илтгэл» гэгчийг олон удаа хэвлэн гаргажээ.

Пэн Бай тэр үеийн ХКН-ын доторхи Чэн Дусю тэргүүтэй оппортунист бүлгийнхний үзэл баримтлал ялангуяа газар тариалангийн асуудлаар баримталж байсан буруу үзэлтэй тууштай тэмцэж байжээ. Пэн Бай тариачдын дотор хувьсгалт үйл ажиллагаа явуулахын зэрэгцээгээр цэрэг армийн дотор ажиллаж Наньчанд болсон 8-р сарын 1-ний хөдөлгөөнийг удирдалцаж, Хятадын ардын чөлөөлөх армийг үүсгэн байгуулах ажилд идэвхтэй оролцсон байна. Тэрээр Гуаньдун мужийн тариачны холбооны зэвсэгт хамгаалалтыг биечлэн удирдаж Хайфун, Лүфэн хошуудын ажилчдын зэвсэгт ангиудтай нэгтгэж 1927 оны 10-р сард хятадад анх удаа ажилчин тариачны холбооны хувьсгалт зөвлөл байгуулжээ. Хэйлуфэний хувьсгалт бүгд найрамдах улсын зөвлөлт засгийн газрыг ажилчин, тариачин, цэргийн төлөөлөгчид оролцсон их хурлаар сонгон бай-

¹ А. М. Малухин, Пэн Бай «Народы Азии и Африк», 1973. № 4, 82-р тал.

² М. Ф. Юрьев, Революция 1925—1927 гг. в Китае, М., 1968, 144-р тал.

гуулж газрын шинэчлэл хийх улаан арми байгуулах, газаргүй тариачдад газар хуваарилах зэрэг ардчилсан арга хэмжээнүүдийг авч явуулжээ. Хэйлуфэний засгийн газар улмаар эмнэлэг, сургууль, ажилчин-тариачны соёлын ордон зэргийг байгуулж, намын байгууллага нь сонин гаргах, суртал ухуулга, хурал цуглаан хийх үзэл суртал-улс төрийн удирдлагыг хангаж байв. Хэйлуфэний коммунист намын хороо 4 сарын хугацаанд 165 үүр байгуулжээ. Энэ бол намаас хөдөөд явуулсан ажлын чухал үзүүлэлт байсан учир ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1928 оны 1-р сарын 3-ны шийдвэрт Хэйлуфэний зөвлөлийн баялаг туршлагыг нэвтрүүлэх тухай заасан байдаг¹ ажээ.

1928 онд Москвад хуралдсан ХКН-ын VI их хурал Пэн Байн үйл ажиллагаа, түүний гавьяа зүтгэлийг өндөрт үнэлж ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүнээр сонгожээ.

Пэн Бай Намын төв хорооны даалгавраар Гуаньдунаас Шанхайд ирж ХКН-ын Төв хорооны тариачны асуудал эрхлэсэн комиссын даргаар ажиллахын зэрэгцээгээр ажилчин тариачны улаан арми байгуулах ажилд гар бие оролцож байв. Гэвч удалгүй Чан Кайшигийнханд баригдаж улмаар 1929 оны 8-р сарын 31-нд Шанхай хотын Лунхуа хэмээх шоронд Хятадын хувьсгалын сод хүү Пэн Бай цаазлагдаж харамсалтайгаар амь үрэгджээ. Энэ явдлаас хойш 38 жил өнгөрсний дараа «Соёлын хувьсгал» гэгчийн үед улаан хамгаалагчид Пэн Байн хөшөө дурсгалыг эвдэн сүйдэлж, түүгээр үл барам түүний 96 настай эх Жоу Фэнг «газрын эзэн эмэгтэй» хэмээх хаягтай пайз зүүлгэн гудамжаар чирч гулдран шоронд хорьж, хүү Пэн Хун болон бусад төрөл төрөгсдийг хайр найргүй алан хяджээ.² Түүнчлэн Пэн Байн зохиосон «Хайфэн дахь тариачны хөдөлгөөн» номыг «хар» ном хэмээн зарлаж, Пэн Байг маогийн үзэл суртлын дайсан, хятадын хувьсгалын урвагч хэмээн хашгичиж байв.

Ард түмнийг жигшүүлэхийн тулд Хайфэн хотын хөл үймээн ихтэй нэгэн гудамжинд Пэн Байн ач хүү Пэн Кэ-гийн толгойг тавин доромжилжээ.

Мао Зэдүн амьд ахуй дээрээ хятадын үй олон шударга коммунистууд, тэдний дотны хүмүүсийн амь нас, алдар нэрийг бүрэлгэн сүйтгэсний дотор хятадын цогт хувьсгалч Пэн Бай ийнхүү орсон байна.

Гэвч хятадын хэвлэлд Пэн Байн үйл ажиллагааг Мао Зэдүн үнэлж байсан мэт бичиж байна.³ Мао Зэдүний шууд удирдлагаар хийгдсэн ХКН-ын 40 гаруй жилийн амьдралын дотор гарсан бүхий л эмгэнэлт явдал, «соёлын хувьсгал» гэгчийн үеэр хийсэн харгислал, аллага таллага, нугалаа завхралыг бээжингийн эрх баригчид аанай л Мао Зэдүнээс булзааруулан зайлуулахыг оролдолхийлж байна

Гэвч Хятадын хувьсгалын түүхэнд Пэн Байн байгуулсан гавьяа хэзээд мөнх үлджээ. Хятадын ард түмний гэрэлт ирээдүйн төлөө амь бие хайрлахгүй тэмцсээр амь үрэгдсэн сод хүү Пэн Байн үйл ажиллагааг Хятадын ард түмэн, даян дэлхийн хувьсгалт ард түмэн хэзээ ч мартахгүй.

Хятадын хувьсгалын цогт тэмцэгч, нэрт коммунист Пэн Бай цаазлагдсаны 50 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлыг БНМАУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэн эрхлэн явуулсан юм. Монголын ард түмэн Пэн Байн үйл ажиллагааг өндөр үнэлэн үздэг юм.

Н. Алтанцэцэг

¹Лиши яньцзю, 1958, № 10, 10-р тал.

²Жэньминь жибао, 1978. VIII. 31.

³Жэньминь жибао, 1979. II. 12